



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 4/25

Баян-Өндөр сум

Гамшигаас хамгаалах мэргэжлийн ангийг  
батлах тухай

Гамшигаас хамгаалах тухайн хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 заалт, Монгол улсын Шадар сайдын 2013 оны 07 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Болзошгүй гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах хойшуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгүүлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, шаардлагатай багаж хэрэгслээр хангах, тэдгээрийг гамшигийн голомтод ажиллуулах зорилгоор гамшигаас хамгаалах мэргэжлийн ангийг 1 дүгээр, гамшигаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарийг 2 дугаар, гамшигаас хамгаалах бүтэц зохион байгуулалтыг 3 дугаар, гамшигаас хамгаалах штабын шуурхай бүлгийг 4 дүгээр, орон тооны бус штабын зохион байгуулалтыг 5 дугаар, мэдээлэл дамжуулах бүдүүвчийг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагын гамшигаас хамгаалах төлөвлөгөөг удирдан боловсруулж, штабын дүрмийг мөрдөн жилийн ажлын төлөвлөгөө хэрэгжүүлэх, тодотгох, тайлан шаардлагатай мэдээ судалгааг мэргэжлийн байгууллагад хүргэн ажиллахыг гамшигаас хамгаалах штабын дарга (Ц.Лхагвасүрэн)-д даалгасугай.

3. Гамшиг, аюул ослын эсрэг эмзэг байдлын үнэлгээг хийлгэж, хүн ам, эд хөрөнгө, баримт бичгийг аюулгүй газар шилжүүлэх "Нүүлгэн шилжүүлэх тусгай төлөвлөгөө"-г шинэчлэн батлуулж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулахад шаардагдах байр, техник хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн нөхөн сэлбэх арга хэмжээ авч ажиллахыг байгууллагын тогтвортой ажиллагаа харуулсан туслахад, Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд зарлан мэдээллийг шуурхай хүргэх журам, бүдүүвчийг шинэчилж, урьдчилан сэргийлэх ухуулах сурталчилгааг тогтмол явуулан, гамшигийн голомтод холбооны хэрэгслийн найдвартай ажиллагааг ханган ажиллахыг холбоо зарлан мэдээлэл хариуцсан ажилтанд, Байгууллагын төсөвт тухайн жилд гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх сургалт болон учирсан хохирлыг арилгахад шаардагдах хөрөнгийг тусгаж батлуулах, томилогдсон бие бүрэлдэхүүнээр учирсан хохирлыг арилгахад шаардагдах хөрөнгийг тусгаж батлуулах, томилогдсон бие бүрэлдэхүүнээр учирсан хохирлыг арилгаж, хойшигуулшгүй сэргээн босгох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг штабын даргад тус тус үүрэг болгосугай.

4. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажилтны сургалтын төлөвлөгөөг батлуулан, сургууль, дадлага зохион байгуулах, мэргэжлийн ангийн хүн, техник хүч хэрэгслийн бэлэн байдлыг ханган ажиллахыг сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтанд даалгасугай.

ДАРГА

О.АРИУНГЭРЭЛТ



Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын  
даргын 2023 оны 06 сарын 05-ний өдрийн  
№ 9/Б-р тушаалын 1 дүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН

Мэргэжлийн ангийн дарга: (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Гамшигас хамгаалах штабын дарга:

Ц.Лхагвасүрэн (Нийгмийн ухааны сургалт хариуцсан мэргэжилтэн)

Хэв журам, эд хөрөнгө хамгаалах асуудал хариуцсан туслах:

Д.Дашням (Хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

Холбоо зарлан мэдээлэл, сурчилгаа хариуцсан туслах

Н.Даваахүү (Гадаад хэлний сургалт хариуцсан мэргэжилтэн)

Сургалт мэргэжлийн ангийн бэлэн байдал хариуцсан туслах:

Л.Шүр-Эрдэнэ (Сургалт арга зүй судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

Байгууллагын тогтвортой ажиллагаа хариуцсан туслах:

Л.Тайвантуул (Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн)

Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан туслах:

Д.Эрдэнэчимэг (Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн)

Аж ахуйн хангалт хариуцсан туслах:

Н.Төртогтох (Нярав)

Аврах гал унтраах бүлэг хариуцсан туслах:

А.Пүрэвжаргал (Нягтлан бодогч)

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын  
даргын 2023 оны 06 сарын 05 өдрийн  
№9/45-р тушаалын 2 дугаар хавсралт

## ГАЛААС ХАМГААЛАХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ГИШҮҮДИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

### МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ДАРГА:

1. Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед эрэн хайх аврах хойшлуулшигүй сэргээн босгох ажлыг удирдах, гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулах тодотгох, түүнийг хэрэгжүүлэх талаар гамшгаас хамгаалах сургалт, дадлага зохион байгуулах;
2. Жилд хоёр удаа /1 ба 7 дугаар сард/ мэргэжлийн ангийн хүч хэрэгсэлийн тооцооны мэдээг маягтын дагуу гаргаж харьялаах төв, орон нутгийн Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад хүргүүлэх;
3. Бие бүрэлдэхүүнийг гамшгийн аюулаас хамгаалах арга дадалд сургах, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед бие бүрэлдэхүүнийг өдөр тутмын удирдлагаар хангаж ажиллах;
4. Байгууллагын эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх;
5. Мэргэжлийн ангийг гамшигтай тэмцэх зориулалтын автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах ажлыг байгууллагын төсөвт тусгаж шийдвэрлэх арга хэмжээг авах.
6. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед хоол хүнс, цэвэр ус, орон байр, техник хэрэгсэл, шатах, тослох материал, дулаан хувцас, багаж хэрэгслээр хангаж, хувийн бэлтгэлийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах;
7. Онцгой байдлын газарт жилийн ажлаа тайлагнаж, гамшиг осолтой тэмцэх тусгай үүрэг гүйцэтгэсэн бол мэдээг холбогдох дээд байгууллагад тухай бүрт нь мэдээлэх ажлыг зохион байгуулах.

### ГАМШГААС ХАМГААЛАХ ШТАБЫН ДАРГА:

1. Мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;
2. Бие бүрэлдэхүүнийг гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах, дадлага сургууль хийх.
3. Гамшгаас хамгаалах дайчилгаагаар ажиллах хүн, техникийн судалгаа гаргах, тодотгох, нүүлгэн шилжүүлэх ажлыг төлөвлөх;
4. Онцгой комиссын гаргасан шийдвэрийг өөрийн мэргэжлийн ангид хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
5. Гамшгийн цагийн байдлыг үнэлж, шийдвэр гаргахад мэргэжлийн ангий даргад дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, хөрш байгууллага, мэргэжлийн ангитай харилцан ажиллагааг зохион байгуулах;
6. Мэргэжлийн ангийг гамшгийн голомтод аврах ажиллагааг явуулахад удирдан зохион байгуулах, ажиллах нөхцлөөр хангах;
7. Барилга байгууламжийн судалгааг гаргах, паспортжуулах, гамшгийн аюулд өртөх зэрэглэлийг тогтоох, ашиглалтад хяналт тавих;
8. Байгууллагынхаа эрсдэл, эмзэг байдлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.

### ХОЛБОО ЗАРЛАН МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН:

1. Гамшгаас урьдчилан сэргийлэх болон гамшгийн үеийн бүх төрлийн холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах, мэргэжлийн ангийн даргад дэмжлэг үзүүлэх;
2. Холбоо зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, жилд 2 удаа төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэст мэдэгдэх;

- Дээд шатны мэргэжлийн байгууллагад гамшгийн нөцөл байдлын мэдээг дамжуулах, хүлээн авах, холбооны тасралтгүй ажиллагааг бүрдүүлэх;
- Бие бүрэлдэхүүнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага эзэмшигүүлэх, гамшгийн аюулгүйн тухай дохио, сээрэмжлүүлэх мэдээллийг хүргэх бүдүүвчийг боловсруулж шалгаж байх.

#### **ХЭВ ЖУРМЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН:**

- Дайчилгаагаар ажиллах тээврийн хэрэгслийн судалгааг гаргах, бэлэн байдлыг шалгах, хөдөлгөөн үйлдэх чиглэлийн талаар зааварчилгаа өгөх;
- Гамшгаас хамгаалах дайчилгаа зарлан явуулах ажилд дэмжлэг үзүүлэх.

#### **СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН АЖИЛТАН:**

- Гамшгийн нөхцөл байдал, хор уршгийг арилгах арга хэмжээний талаар мэргэжлийн ангийн, байгууллагуудад тайлбарлан таниулах;
- Гамшгаас хамгаалах сургууль, дадлага явуулахад шаардлагатай танхим дадлагын талбай талбай бэлтгэх асуудал хариуцах, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний гамшгаас хамгаалах сургалтыг зохион байгуулах;
- Гамшгийн аюулаас сээрэмжлүүлэх сурталчилгааны материалыаар хангах.

#### **ХҮН ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХАРИУЦСАН АЖИЛТАН:**

- Гамшигт нэрвэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, гэмтлийн зэрэглэлээр нь ялгах, болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;
- Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг сургаж, бэлтгэх, багаж хэрэгслээр хангах, бэлэн байдлыг хангудаа;
- Бие бүрэлдэхүүний цусны бүлгийг тодорхойлох, донорын тоог нэмэгдүүлэх, эрүүл ахуйн, ариун цэврийн арга хэмжээг сахиулах;
- Удирдлагын байр, дамжин өнгөрөх цэг, хүлээн авах байруудыг бэлтгэх, хор уршгийг арилгах ажлыг зохион байгуулах;
- Хүн амд халдварт зоонозын өвчин, олон улсын хөл хориот өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, шаардлагатай үед хорио цээрийн дэглэм тогтоох.

#### **ГАМШГААС ХАМГААЛАХ НӨӨЦ, ХАНГАЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН:**

- Мэргэжлийн ангийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх хангалтын төлөвлөгөөг боловсруулахмэргэжлийн ангийн даргыг мэргэжлийн зөвлөмжөөр хангах;
- Гамшгийн хор уршгийг арилгахад шаардагдах сэлбэг, хэрэгсэл, шатах тослох материал хоол хүнс, хувцас, бусад бараа, материалын нөөцийг бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, нөхөн сэлбэх;
- Бие бүрэлдэхүүний хамгаалах хэрэгсэл, түүний ашиглалт, хадгалалтад хяналт тавих, үзлэг шалгалт, засвар үйлчилгээ хийх;
- Дайчилгаагаар ажиллахад аврах ажлын зориулалттай техник, багаж хэрэгслийн судалгааг мэргэжлийн ангийн орлогч даргад гаргаж өгөх;
- Аврах ажлын багаж хэрэгслийг засварлах, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангудаа, нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах, гамшгийн голомтод ажиллагсдын түр орон сууц, ус, хүнс, эмнэлгийн хангалтыг зохион байгуулах.

#### **СЭРГЭЭН БОСГОЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН:**

- Гамшгийн үед мэргэжлийн ангийн даргыг хохирлын талаар мэдээллээр хангах, тогтвортой ажиллагааг хангах төлөвлөгөөг боловсруулах;
- Сэргээн босгоход шаардлагатай хүн хүч, түүхий эд, тоног төхөөрөмжийн судалгааг гаргах, нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах;
- Гамшгийн хохирольг шуурхай үнэлэх, дээд байгууллагад илтгэх.

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын  
даргын 2023 оны 06 сарын 05 өдрийн  
№ 8/25-р тушаалын 3 дугаар хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАНЫ БҮТЭЦ,  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Бүлэг	Урьдчилан сэргийлэх талаар хүлээх үүрэг
Холбоо зарлан мэдээлэл, сурчилгаа хариуцсан туслах	<ol style="list-style-type: none"> <li>Томилгоот бүлгийн хаягийн тодотголын шинэчлэн нөхөн гаргах.</li> <li>Ажилтан албан хаагчдын холбооны хэрэгжслийн бэлэн байдлыг тодотгох.</li> <li>Холбоо зарлан мэдээлэл чиглэл хариуцсан туслахуудын ажил үргийг тодотгох.</li> <li>Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах ажиллах дадлага явуулах.</li> <li>Жижүүр дээр байх “Яаралтай цуглар дохиогоор ажиллах” заавар журмыг шинэчлэн сургалт явуулсан байх.</li> <li>Аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэромжлүүлгийг дамжуулж хэвшсэн байх.</li> </ol>
Аврах гал унтраах бүлэг	<ol style="list-style-type: none"> <li>Томилгоот бүрэлдэхүүний хаягийн тодотголыг тухай бүр шинэчлэн нөхөн хангах.</li> <li>Агааржуулалт, гэрэлтүүлэг, цахилгааны төхөөрөмжийн ашиглалтын бүрэн бүтэн байдалд тогтмол хянаж шалгах.</li> <li>Галын хор, гал унтраах анхан шатны багаж зэмсэглэмжийг тоо хэмжээнд нь хургэн бэлэн байдлыг хангах.</li> <li>Аврах гарц, хаалтыг чөлөөлж, тэмдэг, тэмдэглэгээ, аваарын гэрэл байрлуулах.</li> <li>Хорт утааны баг, аврах олс хоолой шат, дамнуурга зэрэг багаж хэрэгслийг бүрдүүлэн ашиглалтын байдалд хяналт тавих.</li> <li>Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл ашиглах сургалтад хамруулах.</li> <li>Аврах ажиллагаа явуулах аюулгүйн ажиллагааны заавар журмыг хэрэгжүүлэх.</li> <li>Нэрвэгдэгсдийг аюулгүй газар зөөн шилжүүлэх арга, ажиллагааг эзэмшсэн байх.</li> </ol>
Хэв журам сахиулах, эд хөрөнгө хамгаалах бүлэг	<ol style="list-style-type: none"> <li>Томилгоот бүрэлдэхүүний хаягийн тодотголыг шинчлэн нөхөн хангах.</li> <li>Баримт бичиг, мэдээлэл техник тоног төхөөрөмжийн аюулгүй бэлэн байдал хадгалалт зэрэг байнгийн хяналт тавих.</li> <li>Иргэд үйлчлүүлэгчдийн хөдөлгөөнд хяналт тавих, овор ихтэй сэжигтэй бараа, цүнх, саванд зохих журмын дагуу үзлэг шалгалт хийх.</li> <li>Мэдээлэх хэрэгсэл, дохиолол, хяналтын системийн хэвийн ажиллагааг шалгах.</li> <li>Сонор сэромж, хариуцлага чанд сахих, гадны халдлага болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулах</li> </ol>
Эмнэлгийн анхны тусlamжийн нөхөрлөл	<ol style="list-style-type: none"> <li>Эмнэлгийн анхны шатны тусlamж үзүүлэх хичээл сургалтанд хамрагдсан байх</li> <li>Эмнэлгийн тусlamж үзүүлэх мэдлэгийн түвшингээ байнга дээшлүүлсэн байх</li> <li>Ямар ч үед өөртөө болон бусдад эмнэлгийн тусlamж үзүүлж чадах чадамж эзэмшсэн байх</li> </ol>
Байгууллагын тогтвортой ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	<ol style="list-style-type: none"> <li>Машини байнгын бэлэн байдлыг тогтмол шалгаж, шаардлагатай үзлэг үйлчилгээг хийж байх</li> <li>Гэрээт байгууллагуудын холбоо барих дугаар, хаяг байршлыг байнга тодотгох.</li> </ol>


	<p>3. Гамшиг болох түлш шатахуун, машинаар найдвартай хангах нөөц байдлыг тооцоолж бий болгосон байх.</p>
Аж ахуй хариуцсан бүлэг	<p>1. Аврах ажлыг тооны багаж, хувцас, техникийн хэрэгслээр хангах тооцоо хийж, хангалтыг зохион байгуулах.</p> <p>2. Шаардлагатай бараа, материалын нөөцийн судалгаа хийх бүрдүүлсэн байх.</p> <p>3. Гамшигийн голомтод ажиллагсдын багаж, хувцас, техник хэрэгслээр хангалт, шаардлагатай бусад материал болон гамшгаас хамгаалах сургалт, дадлагын нөөц байдлыг тооцоолж бий болгосон байх.</p> <p>4. Нэг бүрийн болон нийтийн хоргодах, далдлах байрыг төхөөрөмжлэх, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх</p> <p>5. Нүүлгэн шилжүүлэлтийн үеийн байршлыг бий болгон тогтоох</p>

Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын  
даргын 2023 оны 06 сарын 05 өдрийн  
№ 4/25 тушаалын 4 дүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ШТАБЫН  
ШУУРХАЙ БҮЛЭГ


- I. Аврах, гал унтраах бүлэг
  1. Ахлагч Няглан бодогч А. Пүрэвжаргал
  2. Аврах, гал унтраагч Мэргэжилтэн Н.Болортuya
- II. Хэв журам сахиулах, эд хөрөнгө хамгаалах бүлэг
  1. Ахлагч Ахлах мэргэжилтэн Д.Дашням
  2. Хамгаалагч Мэргэжилтэн П.Одончимэг
- III. Байгууллагын тогтвортой ажиллагааны бүлэг
  1. Ахлагч Мэргэжилтэн Л.Тайвантуул
  2. Аврагч Мэргэжилтэн Б.Нарангоо
- IV. Эмнэлгийн анхны тусlamжийн нөхөрлөлийн бүлэг
  1. Ахлагч Мэргэжилтэн Н.Эрдэнэчимэг
  2. Идэвхтэн Мэргэжилтэн Ч. Биндэргья
- V. Аж ахуй, хангарт хариуцсан бүлэг
  1. Ахлагч Ахлах мэргэжилтэн Ч. Наранцэцэг
  2. Идэвхтэн Мэргэжилтэн М.Халиунаа
- VI. Зарлан мэдээлэл, сурталчилгаа хариуцсан бүлэг
  1. Ахлагч Мэргэжилтэн Н.Даваахүү
  2. Идэвхтэн Ахлах мэргэжилтэн Д. Эрдэнэжаргал
- VII. Сургалт мэргэжлийн ангийн бэлэн байдал хариуцсан бүлэг
  1. Ахлагч Ахлах мэргэжилтэн Л.Шүр-Эрдэнэ
  2. Идэвхтэн Мэргэжилтэн Д.Энхцэцэг

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын  
даргын 2023 оны 06 сарын 05 өдрийн  
№06/05-р тушаалын 5 дугаар хавсралт




## БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ОРОН

### ТООНЫ БУС ШТАБЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын  
даргын 2023 оны 06 сарын 05 өдрийн  
№ 4/25-р тушаалын 6 дугаар хавсралт



**ГАМШГААС ХАМГААЛАХ ОРОН  
ТООНЫ БУС ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮНД ЗАРЛАН  
МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ БҮДҮҮВЧ**

